



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/342

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1, 2.2.2 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Говь-Алтай салбартай хамтран, Засаг даргын ивээл дор "ЭЭЖ МЕНТОР" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 500 эмэгтэйд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах үйл ажиллагаанд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 4,500,000 (дөрвөн сая таван зуу мянган) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025 A-4

8200010920

